



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 478

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны харьяа “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 117,819,240.00 (нэг зуун арван долоон сая найман зуун арван есөн мянга хоёр зуун дөчин) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Завхан салбарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн зохицуулагч Х.Болор-Эрдэнэ, “Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Завхан салбарын захирал Г.Бадамхатан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.



ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Н.Доржсүрэн

Д.НАРАНГЭРЭЛ

13301983

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтнын газрын 2020
оны 10 дугаар сарын 06-ний
өдрийн 118 дугаар тогтоолын
хавсралт

**Сангийн яамны харьяа Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй тэг үлдэгдэлтэй хөрөнгийн үнийг шинэчлэн
тогтоож балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөн гийн нэр	Ашиглал тад орсон он	тоо шир хэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл/төгрөг/	Шинэчлэн тогтоох үнэ	цаашид ашиг лах жил	Хүлээн авах байгуул лага
1	Тоёото Ланд крузейр- 200	2013	1	117,819,240.00	117,819,240.00	58,909,620.00	3 жил	"АУЭХС" ТӨХК- ийн Завхан салбар
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2 (хоёр)		117,819,240.00 (нэг зуун арван долоон сая найман зуун арван есөн мянга хоёр зуун дөчин)	58,909,620.00 (тавин найман сая есөн зуун есөн мянга зургаан зуун хорин)		